



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтооолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны албан ажлын хэрэгцээнд зориулан 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2 ширхэг автомашин олж авахыг зөвшөөрч, автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.
2. Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:
 - 2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;
 - 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
 - 2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.
3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА


3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000041

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 02 дугаар сарын 11ний өдрийн
25.. дугаар тогтоолын хавсралт



Харилцаа холбооны зохицуулах
хорооны олж авах автомашин

Д/д	Хөрөнгийн нэр	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо ширхэг	Худалдан авах үнийн дээд хязгаар (төгрөг)
1	Суудлын, хөдөлгүүрийн багтаамж 4500 cc хүртэл, суудлын тоо 7	125,000,000.00	2	250,000,000.00
	Нийт дүн		2	250,000,000.00 <i>/хоёр зуун тавин сая/</i>